

**"ЗУДАД НЭРВЭГДСЭН МАЛЧДЫН ХҮҮХДҮҮДЭД  
БОЛОВСРОЛЫН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, СУРГУУЛЬД ТҮШИГЛЭН  
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ" төсөл**

**Хэрэгжих хугацаа:**

2016.08.01-2017.01.31

**Төслийн зорилго:**

Зудын улмаас малчдын хүүхдүүдэд учирсан сөрөг нөлөөг боловсролоор дамжуулан бууруулах, зорилтот сургуулиудын гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхийг бэхжүүлэх

**Үйл ажиллагаа:**

- Малчдын хүүхдүүдэд боловсролын дэмжлэг үзүүлэх
- Сургуулийн орчинд гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг дэмжих

**Төсөл хэрэгжих аймгууд:**


Архангай, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар аймгийн 19 сум, 5 баг

**Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо Арizona төв, 4-р давхар  
Шуудангийн хаяг: Төв шуудан, ШХ-1023 Улаанбаатар 13, Монгол улс  
Утас: +976-11-329365; 329371  
Факс: +976-11-329361

Э-шуудан: [secretary@savethechildren.mn](mailto:secretary@savethechildren.mn)

Вэб хуудас: [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn)

 Save the Children in Mongolia

 Save the Children MN



**СУРГУУЛИЙН ОРЧИНД ГАМШГИЙН**

**ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ**

**ЗӨВЛӨМЖ**

Багш нарт зориулав

## ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Сургуулийн орчинд хүүхэд, багш, ажилтан, эд хөрөнгийг ямар нэгэн гамшигийн эрсдэлээс хамгаалахын тулд доор үзүүлсэн үе шатны дагуу ажиллана.



### 1. Гамшигийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх

**а) Тохиолдож болох гамшигийн төрлүүдийг тогтоох:** Орон нутагт тохиолдох магадлал бүхий гамшигийн төрлүүдийг тогтооно. Ингэснээр гамшигийн төрөл тус бүрт суурилан эрсдэлийг үнэлэх боломжтой болно.

**б) Эрсдэлийг үнэлэх:** Ямар нэг гамшиг тохиолдлоо гэхэд хүүхэд, багш, ажилтан болон бусад эд зүйлд ямар аюул эрсдэл учирч болохоор байна гэдгийг сурагчид болон бусад багш, ажилтнууд хамтран үнэлнэ. Ингэхдээ дараах асуултуудад хариулаарай:

- Сурагчид болон багш, ажилтнууд галаас өөрийгөө хамгаалах, бусдад туслах талаар мэдэх үү?
- Гал унтраах багаж хэрэгслийг хэрэглэж чадах уу?
- Цахилгаан утаснууд ил эсвэл шалбархай байна уу?
- Сургуулийн аврах гарц, хаалга нээлтэй, чөлөөтэй байна уу? гэх мэт.

**в) Эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх:** Өмнөх шатны үнэлгээгээр гарсан аюул эрсдэлийг арилгахын тулд юу юу хийхийг сурагчид, багш нар, ажилтнууд хамтран төлөвлөнө. Тухайлбал дараах зүйлийг төлөвлөж болно:

- Галаас хэрхэн хамгаалах талаар сурагчид, багш ажилтнуудыг сургах, мэдээлэл өгөх
- Гал унтраах багаж хэрэгслийг ашиглаж сурах дадлага сургуулилт хийх
- Цахилгааны утаснуудын шалбархайг янзлах, далдлах
- Сургуулийн аврах гарц, хаалгыг таглаж тавьсан эд зүйлийг өөр газарт тавьж, хаалгыг чөлөөлөх гэх мэт.

Энэ мэтээр эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөхдөө **хэн, хэзээ, хэрхэн, хэнтэй хамтран хийх** зэргийг хамтад нь гаргаарай. Ингэснээр төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх боломжтой болно.

### 2. Хэрэгжүүлэх

Төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлнэ.

### 3. Хянаж үнэлэх

Төлөвлөсөн ажлууд хэрхэн явагдаж байна, ямар үр дүн гарч байна, үр дүнг өгөөжтэй болгохын тулд юу хийх талаар мэдэхийн тулд хянаж үнэлэх хэрэгтэй. Үүнийг мөн л сурагчид, багш нар, ажилтнууд хамтран хийнэ. Тухайлбал дараах асуултуудын дагуу төлөвлөсөн үйл ажиллагаа хэрхэн хэрэгжиж буйг хянаж үнэлж болно:

- Галаас хэрхэн хамгаалах талаар сурагчид, багш, ажилтнууд мэдээлэл авсан уу?
- Хүүхдүүд, багш нар гал унтраах багаж хэрэгсэл ашиглаж сурсан уу?
- Цахилгааны утаснуудын шалбархайг янзалж, далдалсан уу?
- Сургуулийн аврах гарц, хаалгыг чөлөөлсөн үү? гэх мэт

## 4. Сайжруулан хэрэгжүүлэх

Өмнө хийсэн хяналт үнэлгээний дагуу төлөвлөсөн ажил хэрэгжээгүй эсвэл дутуу хэрэгжсэн байвал хэрхэн сайжруулах, цаашид өөр юу хийх талаар төлөвлөгөөндөө нэмэлт өөрчлөлт оруулна. Тэгээд сайжруулсан төлөвлөгөөнийхөө дагуу ажиллана.



Энэхүү шаталсан үйл ажиллагааг тодорхой хугацааны давтамжтайгаар дахин дахин хийх ёстойг мартуузай.

## ГАМШИГ ТОХИОЛДСОН ҮЕД ХҮҮХДЭД СЭТГЭЛЗҮЙН АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

Сургуулийн орчинд ямар нэгэн гамшиг тохиолоо гэхэд хүүхдүүдэд сэтгэлзүйн анхны тусламж хэрхэн үзүүлэх талаар багш та бүхэн мэддэг байх хэрэгтэй.

### Ямар нэг гамшиг тохиолдоход хүүхдүүдийн гаргах хариу үйлдэл

- Айх
- Сандрах
- Уйлах
- Уурлах, бухимдах
- Гутарч шаналах
- Анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байх
- Тоглохоо болих, тоглох нь багасах
- Дуугаа хураах, ярихгүй байх
- Бодолд дарагдах
- Найзуудаасаа хөндийрөх
- Түрэмгий авирлах
- Хөдлөх дургүй болох
- Томчуудын үгийг тоохоо болох
- Хичээлдээ дургүй болох гэх мэт

## Хэрэв хүүхэд дээр дурдсан хариу үйлдэл гаргаж байвал дараах гурван шат бүхий зарчмын дагуу туслаарай:



Хүүхдүүдийг сайтар ажиглан харна. Гар хөл нь бэртсэн эсэх, өлсөж, цангаж, даарч байгаа эсэх, эргэн тойронд нь аюултай зүйл байгаа эсэх зэргийг эхлээд харж шалгана.



Хүүхэд юу ярьж байгаа, түүнд юу хэрэгтэй байгааг сайн сонсоно.



Хоол унд, хувцас хунар, унтах байр гэх мэтээр хангаж буй хүмүүс, байгууллагуудад хүүхдийг хүлээлгэн өгөх, эмч, нийгмийн ажилтан, сэтгэлзүйчтэй уулзуулах гэх мэтээр шаардлагатай үйлчилгээнд холбоно.